

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/21/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
Байхгүй	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**АЛТАЙ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.ЖАНБОТА ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠒ № 115
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Алтай хүүхдийн цэцэрлэг-dugnelt-2.22

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Алтай хүүхдийн цэцэрлэг-dugnelt-2.22

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75215294.95</u>	<u>115667846.54</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	15000000.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	15000000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75215294.95	100667846.54
351	Түүхий эд материал	23000.00	101100.00
35130	Эм боох материал	23000.00	101100.00
354	Хангамжийн материал	75192294.95	100566746.54
35410	Бичиг хэргийн материал	1363470.00	1073750.00
35420	Аж ахуйн материал	21471179.11	23171208.11
35440	Түлш, шагах тослох материал	4076570.00	4502697.30
35460	Хүнсний материал	4346991.89	25349300.89
35470	Бусад хангамжийн материал	43934083.95	46469790.24
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	854692443.08	852140250.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	854692443.08	852140250.70
392	Биет хөрөнгө	849114306.68	846569454.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	847571792.75	873332290.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40494184.32	-64077820.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22413037.00	19846387.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13680903.22	-11668553.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44391216.44	41115185.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24257755.17	-24180497.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	24339600.00	17459600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16138746.80	-10227386.80
39217	Ном	4970250.00	4970250.00
393	Биет бус хөрөнгө	5578136.40	5570796.36
39301	Програм хангамж	183500.00	183500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-155363.60	-162703.64
39303	Бусад биет бус хөрөнгө	5550000.00	5550000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>929907738.03</u>	<u>967808097.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>929907738.03</u>	<u>967808097.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	929907738.03	967808097.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71266177.87	71266177.87
51101	Өмч: - төрийн	71266177.87	71266177.87
512	Хуримтлагдсан үр дүн	574636793.45	612537152.66
51210	Өмнөх үеийн үр дүн	574636793.45	574636793.45
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	37900359.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	284004766.71	284004766.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>929907738.03</u>	<u>967808097.24</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	583,277,940.00	489,304,094.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,710,940.00	6,037,696.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,710,940.00	6,037,696.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	560,567,000.00	483,266,398.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	559,567,000.00	453,719,098.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	31,546,300.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	143,000,000.00	28,140,498.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,020,700.00	425,578,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	29,342,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	29,342,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	431,937,132.19	441,933,065.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	431,937,132.19	441,933,065.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	431,082,532.19	437,460,085.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,055,434.38	313,592,300.00
210101	Үндсэн цалин	272,373,560.38	291,047,700.00
210104	Урамшуулал	23,681,874.00	22,544,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,227,965.62	42,335,000.00
210201	Тэтгэврийн даатгал	27,723,179.00	29,791,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,924,900.00	3,135,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,339,900.00	2,508,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	569,000.00	627,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,670,986.62	6,271,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,833,526.00	28,322,457.70

210301	Гэрэл, цахилгаан	504,766.00	986,200.00
210302	Түлш, халаалт	30,328,760.00	27,336,257.70
2104	Хангамж, бараа материалын зардал	3,819,330.00	6,884,795.00
210401	Бичиг хэрэг	480,610.00	927,750.00
210402	Тээвэр, шатахуун	1,572,280.00	711,815.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,500.00	450,000.00
210404	Ном, хэвлэл	44,000.00	3,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,309,940.00	4,791,430.00
2105	Нормативт зардал	35,262,627.00	14,787,011.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	221,100.00	-
210502	Хоол, хүнс	35,041,527.00	14,749,611.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	37,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2107	Томилолт, зочны зардал	146,500.00	390,600.00
210702	Дотоод албан томилолт	146,500.00	390,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	323,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		73,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,437,149.19	30,824,721.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,120.00	487,570.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,376,029.19	30,337,151.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	854,600.00	4,472,980.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	854,600.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,472,980.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,472,980.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	151,340,807.81	47,371,028.78
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,593,054.80	9,470,669.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	319,412.80	715,538.86
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,273,642.00	8,755,130.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,593,054.80)	(9,470,669.57)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	148,747,753.01	37,900,359.21

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	574,636,793.45		929,907,738.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	574,636,793.45	0.00	929,907,738.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	574,636,793.45	0.00	929,907,738.03
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	574,636,793.45	0.00	929,907,738.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	574,636,793.45	0.00	929,907,738.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			37,900,359.21		37,900,359.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	612,537,152.66	0.00	967,808,097.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	417567000.00	455125900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417567000.00	455125900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385020700.00	425578600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385020700.00	425578600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1000000.00	205000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	205000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31546300.00	29342300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31546300.00	29342300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	413787000.00	454765900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413787000.00	454765900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412932400.00	450292920.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295393500.00	313592300.00
210101	Үндсэн цалин	273068275.00	290186651.00
210104	Урамшуулал	22325225.00	23405649.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39889900.00	42335000.00
210201	Тэтгэврийн даатгал	28206300.00	29791300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2924900.00	3135900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2339900.00	2508700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	569000.00	627200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5849800.00	6271900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31546300.00	29132300.00
210301	Гэрэл, цахилгаан	1368500.00	1368500.00
210302	Түлш, халаалт	30177800.00	27763800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3793480.00	9875900.00
210401	Бичиг хэрэг	718380.00	390600.00
210402	Тээвэр, шатахуун	1293000.00	710400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412500.00	450000.00
210404	Ном, хэвлэл	87900.00	87900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1281700.00	8237000.00
2105	Нормативт зардал	39083900.00	31355520.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244100.00	78100.00
210502	Хоол, хүнс	29619200.00	30642720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9220600.00	634700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	15210000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		15000000.00
210604	Урсгал засвар		210000.00
2107	Томилолт, зочны зардал	146500.00	390600.00
210702	Дотоод албан томилолт	146500.00	390600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	320500.00	396500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20500.00	146500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	250000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2758320.00	8004800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2758320.00	8004800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	854600.00	4472980.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16000.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16000.00	

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	838600.00	4472980.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	838600.00	4472980.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3780000.00	360000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3780000.00	360000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3780000.00	360000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3780000.00	360000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3780000.00	-360000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	454920900.00	450447920.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454920900.00	450447920.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454920900.00	450447920.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313592300.00	313592300.00
210101	Үндсэн цалин	291047700.00	290186651.00
210104	Урамшуулал	22544600.00	23405649.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42335000.00	42335000.00
210201	Тэтгэврийн даатгал	29791300.00	29791300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3135900.00	3135900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2508700.00	2508700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	627200.00	627200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6271900.00	6271900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29132300.00	29132300.00
210301	Гэрэл, цахилгаан	1368500.00	1368500.00
210302	Түлш, халаалт	27763800.00	27763800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10030900.00	10030900.00
210401	Бичиг хэрэг	390600.00	390600.00
210402	Тээвэр, шатахуун	710400.00	710400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450000.00	450000.00
210404	Ном, хэвлэл	87900.00	87900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8392000.00	8392000.00
2105	Нормативт зардал	35828500.00	31355520.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78100.00	78100.00
210502	Хоол, хүнс	35115700.00	30642720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	634700.00	634700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15210000.00	15210000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15000000.00	15000000.00
210604	Урсгал засвар	210000.00	210000.00
2107	Томилолт, зочны зардал	390600.00	390600.00
210702	Дотоод албан томилолт	390600.00	390600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	396500.00	396500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146500.00	146500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	250000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8004800.00	8004800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8004800.00	8004800.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	454920900.00	450447920.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	425578600.00	421105620.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	425578600.00	421105620.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29342300.00	29342300.00
132001	Орон нутгийн төсвөөс	29342300.00	29342300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.00	34.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	175.00	175.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	175.00	175.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	175.00	175.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34.0	34.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20.00	20.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	205000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	205000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	205000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	205000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		205000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	205000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	205000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэг нь 2021 оны хичээлийн жилд "Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" гэсэн зорилготой ажиллаж, дараах үндсэн 3 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Бага насны хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, хэл яриа, харилцаа, гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэх
- ❖ Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сурах, хөгжих үйлийг дэмжих хичээл, сургалтын үйл ажиллагаанд тэдний оролцоог тэгш хангах, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх

- ❖ Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглахад багш нарын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг чиглүүлж багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд шалгалт хийгдээгүй байна.

Сумын засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2021 онд 2 удаа хяналт шалгалт хийж үйл ажиллагаа болон бичиг баримт хөтлөлтийн талаар, аймгийн Боловсролын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 9,10-р сард хяналт шалгалт хийж зөвлөмж өгч ажилласан байна. Тухайн үед гарсан зөрчлүүдийг тухай бүрд арилгаж зөвлөмжийн хариуг хүргүүлсэн байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй боловч эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитаас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 437.0 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.9 сая төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.0	15000.0	15000.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	75215.3	100667.8	25452.6
Үндсэн хөрөнгө	854692.4	852140.2	-2552.2
Нийт хөрөнгө	929907.7	967808.1	37900.4
Өр төлбөр	0.0	0.0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	929907.7	967808.1	37900.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	929907.7	967808.1	37900.4

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 15.0 сая төгрөг болж өссөн нь Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг “Чарж” ХХК-ний дансанд хөрөнгө нийлүүлэхээр шилжүүлж, шинээр авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 100.7 сая төгрөг болж 25.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 54.0 сая төгрөгийн материал худалдан авч, 5.7 сая төгрөгийн материалыг үнэгүй хүлээн авсан 25.6 сая төгрөгийн материал зарцуулж, аж ахуйн данснаас 1.5 сая төгрөг, бусад хангамжийн материал данснаас 7.2 сая төгрөгийн материалыг Алтай сумын ИТХ-ын 2021 оны 12 сарын 16-ний өдрийн 35 дугаар тогтоолоор акталж данснаас хассан, аж ахуйн материал болон бусад хангамж материал дансанд шинээр нэмэгдсэн бүлэгт зөөлөн эдлэл худалдан авсан, мөн хүнсний материал махыг их хэмжээгээр нөөцөлснөөс шалтгаалжээ.

Хүнсний материалын дансанд оны эхэнд 4.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 30.6 сая төгрөгийн хүнс худалдан авч, өмнөх оны эхний авлагаас 5.1 сая төгрөгийн хүнсийг барагдуулан орлого авч 14.7 сая төгрөгийн материалыг зарцуулж жилийн эцэст 25.3 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй гарснаас үзэхэд хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн нь цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой чанар байдал алдаж муудах эрсдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 852.1 сая төгрөг болж 2.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 0.4 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 28.4 сая буюу нийт 28.8 сая төгрөгөөр нэмэгдэж, аймгийн ИТХ-ын 2021 оны 12-р сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолоор 15.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, үндсэн хөрөнгөнд 30.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна. Тайлант онд акталсан бараа материал, үндсэн хөрөнгийг сумаас нэгдсэн журмаар устгахаар болсон тул устгалын акт гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 967.8 сая төгрөг болж 37.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 37.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 489.3 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 94.0 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй бараа материал авсан, тайлант онд үйл ажиллагаа түр хугацаагаар зогсоож зарим зардлыг төвлөрүүлсэнтэй холбоотой материаллаг хэмжээний өөрчлөлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 10.0 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусад урсгал шилжүүлгээс төвлөрүүлэх болон цалингийн зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2020 оны анх батлагдсан төсөв 456.5 сая төгрөг, тодотгосон төсөв 454.9 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 1.6 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Цалин хөлсний зардлыг 3.9 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.2 сая төгрөгөөр, хангамж материалын зардал 7.0 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 15.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний материалын зардал 6.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, урамшуулал цалингийн зардлыг 2.7 сая төгрөгөөр, хоолны зардлыг 31.5 сая төгрөгөөр анх баталснаас бууруулж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 454.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 450.4 сая төгрөгийг зарцуулж, хоолны зардлын хэмнэлтээс 4.4 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 450.4 сая төгрөг буюу 99 хувьтай байна.

Нийт төсвийн 69 хувийг цалин, 9.4 хувийг НДШ-ийн зардал, 6.5 хувийг тогтмол зардал, 2.2 хувийг хангамж бараа материалын зардал, 6.9 хувийг норматив зардал, 3.4 хувийг урсгал засварын зардал, 0.08 хувийг дотоод албан томилолтын зардал, 0.08 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 1.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 0.2 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 313.6 сая төгрөг, НДШ-ийн зардалд 42.3 сая төгрөг, халаалтын зардалд 29.1 сая төгрөг, хоолны зардалд 30.6 сая төгрөг нийтдээ 415.6 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 454.9 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 415.6 сая төгрөгийг хасахад 39.3 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 3.9 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс хэмнэлт гаргаж ажиллаагүй тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу Багшийн хөгжлийн танхим ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг сургуулийн захирал “Чарж” ХХК-тай тоног төхөөрөмж нийлүүлэх 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдөр №5 тоот ажлын гэрээ хийж, тус компанийн Голомт банкны 1415141092 дансанд шилжүүлэн шинээр авлага үүсгэсэн байна. Гэрээнд тоног төхөөрөмжийг 2022 оны 2 дугаар сарын 10-ны дотор нийлүүлэхээр заасан боловч одоогоор хүлээж аваагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 450.4 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 450.4 төгрөгийн 149 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2 мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой зөрчилд 1 зөвлөмж, авлага, өглөг, хүнсний материалын бүртгэл тайлагналтай холбоотой 16.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд албан шаардлага, зөвлөмжийг зөрчлийг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хүнсний материалын үлдэгдэл нэмэгдсэн, их хэмжээний нөөц үүсгэсэн асуудалд анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 3.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 29.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 39.3 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь 3.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн хүнсний материалын дансанд оны эцэст 25.3 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй гарснаас үзэхэд хүнсний материалыг бодит хэрэгцээнээс их хэмжээгээр нөөцөлсөн нь цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой чанар байдал алдаж муудах, улмаар төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материалыг бодит хэрэгцээнд үндэслэн худалдан авалт хийх, гарч болох эрсдэлийг урьдчилан тооцож, чанар байдлаа алдаж муудахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс			
			Залруулга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн	1	29.2					1	29.2		